



ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН  
ДАРГА-ЕРӨНХИЙ ЭМЧИЙН  
ТУШААЛ

2023 оны 07 сарын 21 өдөр

Дугаар 8460

Улаанбаатар хот

Үйлдвэрийн ослыг судлан бүртгэх орон тооны бус  
байнгын комиссын ажиллах журам батлах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 21.1.8; 29 дүгээр зүйл, Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоол, Хөдөлмөрийн дотоод журмын 18.4.4 дугаар зүйл, Батлан хамгаалах сайдын 2015 оны А/335 тушаалын 2.17; 2.18; 2.19; 3.1.15; дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үйлдвэрийн ослыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын удирдлагын багийг нэгдүгээр хавсралтаар, Үйлдвэрийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх журам хоёрдугаар хавсралтаар, Үйлдвэрийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх актыг гуравдугаар хавсралтаар, Үйлдвэрийн осол, хурц хордлогын тухай яаралтай мэдэгдэх хуудас дөрөвдүгээр хавсралтаар, Үйлдвэрийн ослын хурлын бүртгэл тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг орон тооны бус байнгын комиссад танилцуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Анударь)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг штабын дарга (хурандаа Ж.Ганхуяг)-д даалгасугай



Цэргийн тэв эмнэлгийн дарга-  
ерөнхий эмчийн 2023 оны 7 дугаар  
сарын 21 -ны өдрийн 11:00 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

1117138660  
УКВ0050 9095764

ҮЙЛДВЭРИЙН ОСЛЫГ СУДЛАН БҮРТГЭХ ОРОН ТООНЫ БУС БАЙНГЫН  
КОМИССЫН УДИРДЛАГЫН БАГ

Зөвлөлийн дарга:

Тасгийн дарга-дотор, эмнэлзүйн  
хордлого судлалын их эмч

Нарийн бачгийн дарга :

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл  
ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн;

Гишүүд:

Эмнэлгийн ахлагч  
Аюулгүй байдал, эрсдэл хариуцсан  
менежер;  
Эмнэлгийн тоног төхөөрөмжийн  
албаны дарга – эмнэлгийн тоног  
төхөөрөмжийн инженер;  
Халдварын сэргийлэлт хяналтын  
албаны дарга-тархвар судлагч;  
Сувилахуйн албаны дарга

Цэргийн төв эмнэлгийн дарга-  
ренхий эмчийн 2023 оны дугаар  
сарын 21 -ны өдрийн дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

1117138660  
УКВ0050 9095784

## ҮЙЛДВЭРИЙН ОСЛЫГ СУДЛАН БҮРТГЭХ ОРОН ТООНЫ БУС БАЙНГЫН КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

### НЭГ. ЗОРИЛГО:

Үйлдвэрийн ослыг судлан бүртгэх үндсэн зорилго нь ажлын байранд гарсан осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, давтан гаргахгүй байхад чиглэгдсэн.

### ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ:

Энэхүү журмыг “Цэргийн төв эмнэлэг”-ийн нийт клиник тасаг, алба нэгж нийт ажилтан, албан хаагчид дагаж мөрдөнө.

### ГУРАВ. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР:

- **Үйлдвэрлэлийн осол:** гэж хөдөлмөр эрхлэгч иргэн хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөхийг
- **Хурц хордлого:** гэж цацраг болон биологийн идэвхт бодис, химиин хорт бодисын нөлөөгөөр хурц, цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг;
- **Хөдөлмөрийн чадвар алдалт:** /ХЧА/ гэж ослоос улбаатай өвчин эмгэг нь архаг удаан явцтай, эрхтэн бие махбодын тогтоц, үйл ажиллагааг гэмтээж доройтуулсны улмаас үндсэн мэргэжлийнхээ ажлыг гүйцэтгэж чадахгүй болж, хийсэн эмчилгээнд засрахгүй, байнгын архаг байдалтай болоход хүргэсэн гэмтлийг;
- **Хөдөлмөрийн чадвар түр алдалт:** /ХЧТА/ гэж Хөдөлмөр эрхлэх явцад авсан гэмтлийн улмаас ажилтан гэмтэл авсны дараагийн өдрөөс 180 хоногт үндсэн ажил үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон гэмтлийг /МУ-ын нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчиний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай 14, 16 зүйлийн заалт/
- **Хөнгөн ажилд шилжүүлсэн гэмтэл:** гэж хөнгөн гэмтэл, хордлогын үед үссэн эмгэг өөрчлөлтийн улмаас ажилтан өөрийн үндсэн ажлаа үргэлжлүүлэн хийх боломжгүй боловч эмчийн зааврын дагуу тохирох хөнгөн ажилд шилжүүлэн ажиллуулах боломжтой гэмтлийг.

### ДӨРӨВ: ҮЙЛДВЭРИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ЗАРЧИМ:

3.1. Хөдөлмөр эрхлэгч иргэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод дараах тохиолдолд өртсөний улмаас гэмтсэн, өвчилсөн, эсхүл амь насаа алдсан бол акт тогтооно:

- 3.1.1. Ажлын байрандаа ажил үүргээ гүйцэтгэж байх үед;
- 3.1.2. Ажил олгогч болон эрх бүхий бусад байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу албан томилотоор буюу дайчилгаагаар ажил, үүргээ гүйцэтгэж байх үед;

3.1.3. Ажлын байр, нэгж, хэсэг, салбарын хооронд байнга явж ажил, үүрэг гүйцэтгэдэг ажилтан ажлын цагаар бүх төрлийн тээврийн хэрэгсэл, ердийн хөсгөөр буюу явган явж байх үед;

3.1.4. Ажилтан ажил эхлэхийн өмнө болон дууссаны дараа ажлын байрандаа амрах, багаж хэрэгслээ эмхэлж, цэгцлэх, хувцсаа солих, усанд орох, ажил хүлээлцэх үед;

3.1.5. Ажилтан ажилдаа ирэх, буцах зам (ажлын байр болон ажилтай холбоотой сургалтад оролцож байгаа, түр болон байнга оршин суудаг газар) бүх төрлийн тээврийн хэрэгсэл, явган явж байх үед гарсан ослыг судлан бүртгэхдээ чиглэл, маршрут, цаг хугацаа зэргийг үндэс болгоно

3.1.6. Ажил, үүргээ гүйцэтгэх үед байгаль, цаг уур, гал, усны гэнэтийн аюул, цацраг идэвхт болон химиин бодисын нөлөөлөл, биологийн гаралтай гоц халдварт өвчин үүсгэгч, хөнөөх хэрэгсэл, сүйрэл дэлбэрэлт зэрэг гамшигийн үед;

3.2. Үйлдвэрийн осол хурц хордлого гарсан даруйд Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимыг санаатай зөрчсөн болон согтууруулах ундаа мансууруулах бодис хэрэглэсний улмаас осолд өртсөн, гэмт хэрэг үйлдэх үед өөрийн биед гэмтэл учруулсан нь нотлогдсон тохиолдолд орон тооны бус байнгын комисс нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн актад энэ тухай тусгайлан тэмдэглэх ба үйлдвэрийн осол хурц хордлогод тооцохгүй.

#### **ТАВ. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛЫГ СУДЛАН БҮРТГЭХ ОРОН ТООНЫ БУС БАЙНГЫН КОМИСС, ТҮҮНИЙ АЖИЛЛАХ ДҮРЭМ:**

4.1. Цэргийн төв эмнэлгийн үйл ажиллагааны явцад гарсан үйлдвэрлэлийн ослын шалтгааныг судалж тогтоох, бүртгэх, акт, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус байнгын комиссыг Дарга-Ерөнхий эмчийн тушаалаар байгуулан томилно.

4.2. Комиссын гишүүдийн тоо 3-9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулна

4.3. Энэхүү журмын 4.1-т заасан комисс (цаашид "комисс" гэх) нь осолдогч уг журмын Хавсралт №1-р баталсан "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт" (цаашид "акт" гэх)-ийн дагуу үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэнэ

4.4. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг тогтоосон актад комиссын дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна. Актад үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гаражад хүргэсэн шалтгаан, хүчин зүйлийг тогтоож, /осолдогч нас барсан тохиолдолд гэрч/-ийн гаргасан тайлбарыг хавсаргана.

4.5. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судалж тогтоосон акт, дүгнэлтийг 4 хувь үйлдэж, осолдогч буюу гэр бүлийн хүмүүст, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцагчид, акт батлагдсан өдрөөс ажлын 3 өдөрт багтаан тус бүр 1 хувийг хүргэж өгнө. Комисс акт, дүгнэлтийн 1 хувийг архивын нэгж болгон хадгална.

#### **ЗУРГАА. КОМИССЫН ҮҮРЭГ, ЭРХ:**

5.1. Комисс нь дараах эрхтэй байна. Үүнд:

5.1.1. Үйлдвэрлэл, ажлын байранд нэвтрэн орж, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын нөхцөл байдалтай биечлэн танилцах;

5.1.2. Үйлдвэрлэлийн ослын шинж байдлаас хамааран мэргэжилтэн, шинжээч оролцуулах, ослыг бүртгэх ажилд зөвлөгөө, тусламж авах, ослын талаар техникийн

тооцоо, лабораторийн шинжилгээ, туршилт хийлгүүлэх, дүгнэлт гаргуулах, эрсдэлийн үнэлгээ хийлгүүлэх;

5.1.3. Осолдогч болон осол, хурц хордлого гарагаар үед байсан гэрчийн этгээд, мэргэжилтэн, удирдах ажилтнаас мэдээлэл, ярилцлага авах, холбогдох бичиг баримттай танилцах;

5.1.4. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлах явцад шаардлагатай ажлын байр, техник хэрэгсэл, унаагаар хангуулах

5.2. Комисс нь дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

5.2.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх явцад гарсан гомдол, санал хүсэлтийг хүлээн авч, магадлан шалгаж шийдвэрлэх;

5.2.2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгааныг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулах;

5.2.3. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгааныг судлан тогтоосон акт, дүгнэлтийг үндэслэн нийт ажилтнуудад сэргэжилүүлэг хийх, сургалт зохион байгуулах, ажил олгогчид шаардлага, зөвлөмж хүргүүлэх;

## **ДОЛОО. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХЭД БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ:**

6.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

6.1.1. Осолдогч бүрээр гаргасан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын акт /Хавсралт №1/

6.1.2. Осолдогчоос авсан тайлбар, ярилцлагын тэмдэглэл, осолдогч нас барсан тохиолдолд гэрчийн тодорхойлолт, түүний ярилцлагын тэмдэглэл;

6.1.3. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлоготой холбоотой асуудлаар холбогдох хүмүүсээс авсан мэдээлэл, ярилцлагын тэмдэглэл;

6.1.4. Осолдогчийн ажилд орсон тухай шийдвэр, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт, аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч байсан бүртгэл, сургалтад хамрагдсаныг гэрчлэх болон бусад шаардлагатай баримтын хуулбар;

6.1.5. Аюулгүй ажиллагааны дүрэм, журам, заавар, тушаал, хууль тогтоомжийн холбогдох хэсгийн хуулбар;

6.1.8. Тухайн ажлын байранд хийсэн эрсдэлийн үнэлгээний хуулбар;

6.1.9. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаар яаралтай мэдэгдэх хуудас.

6.2. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт (дүгнэлт гаргасан тохиолдолд)

6.2.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас учирсан гэмтлийн зэрэг, эмнэлгийн болон мэргэжлийн байгууллагын шинжээчийн дүгнэлт, лабораторийн шинжилгээ, туршилтын дүн;

6.2.2. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт (дүгнэлт гарсан тохиолдолд);

6.2.3. Холбогдох хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн, шинжээч болон мэргэжлийн байгууллагын дүгнэлт (дүгнэлт гарсан тохиолдолд);

6.2.4. Осолдогч нас барсан тохиолдолд цогцост задлан шинжилгээ хийсэн тухай шүүх эмнэлгийн дүгнэлт;

6.2.5. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг тогтоосон акт.

## **НАЙМ. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ ХУРЦ ХОРДЛОГО ГАРСАН ТУХАЙ МЭДЭЭЛЭХ, ТАЙЛАН ГАРГАХ:**

7.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тухай осолдогч өөрөө, эсхүл осол, хордлогыг анх харсан хүн ажил олгогчид нэн даруй мэдээлнэ

7.2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тухай мэдээллийг хүлээн авмагц ажил олгогч, комисс нь осолдогчид эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлж, эмнэлэгт хүргүүлнэ. Хүнд буюу хүний амь нас хохирсон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тохиолдолд орон нутгийн мэргэжлийн хяналт болон цагдаагийн байгууллагад тохиолдолд орон нутгийн мэргэжлийн хяналт болон цагдаагийн байгууллагад Хавсралт №2 "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тухай яаралтай мэдээлэх хуудас" болон утсаар мэдэгдэнэ.

7.3. Ажил олгогч нь комисс ирж судалгаа, шинжилгээ хийх хүртэлх хугацаанд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан ажлын байрыг хамгаалалтад авна.

7.4. Комисс нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тухай мэдээг актын хамт тухайн орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагад хүргүүлнэ.

## **ЕС. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГОТОЙ ХОЛБОГДСОН МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ:**

8.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаар гарсан ослын актыг ажил олгогч, ажилтан зөвшөөрөхгүй бол гомдоо хөдөлмөрийн мэргэжлийн хяналт хариуцсан төрийн захиргааны байгууллага болон шүүхэд гаргаж холбогдох хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.

8.2. Үйлдвэрлэлийн осол гарснаас хойш 6 сарын хугацаа өнгөрсөн тохиолдолд үйлдвэрлэлийн ослын актыг нөхөн тогтоохгүй.

Цэргийн төв эмнэлгийн дарга-  
ерөнхий эмчийн 2023 оны 7 дугаар  
сарын 21 -ны өдрийн 14:00 дугаар  
тушаалын гуравдугаар хавсралт

1117138660  
УКВ0050 9095764

## ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭСЭН АКТ

1. Аж ахуйн нэгж байгууллагын  
нэр.....

Байгууллагын хаяг /аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, гудамжны  
нэр/.....

2. Өмчийн хэлбэр

3. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсэн хүний  
овог..... нэр.....

Төрсөн..... он..... сар..... өдөр..... нас..... хүйс.....

Регистрийн дугаар.....

Нийгмийн даатгалын дэвтрийн дугаар.....

Албан тушаал.....

Боловсрол.....

Мэргэжил.....

Ажилд орсон..... он..... сар..... өдөр.....

Тушаал шийдвэрийн дугаар.....

Нийт ажилсан жил .....

4. Байгууллагын захиргаанаас аюулгүй ажиллагааны урьдчилсан  
зааварчилгаа авсан байдал .....

5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан  
байдал.....

6. Эрүүл мэндийн үзлэгт хамгийн сүүлд  
орсон..... он..... сар..... өдөр..... онош.....

7. Оршин суугаа хаяг.....

8. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого  
гарсан..... он..... сар..... өдөр..... цаг.....

9. Осол, хурц хордлогын гарсан цех, тасаг, хэсэг, ажлын байрны  
нэр.....

10. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын байдал /хөнгөн, хүнд, нас  
барсан/.....

11. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсэн хүний тоо /булэг осол  
эсэх/.....

12. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын гэмтлийн төрөл, ангилал: /зур/ яс  
хугарах, үе мултрах, зөвлөн эд гэмтэж, бяцарсан, тасарсан, зүсэгдсэн, түлэгдсэн,  
гадаад дотоод гэмтэл, биологи, химийн бодсын үйлчлэл,  
бусад.....

13. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гаражад хүргэсэн шалтгаан, хүчин зүйл.....

14. Комиссын дүгнэлт: /Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарахад шууд нелөөлсөн хүчин зүйл, үйл ажиллагааны тухай тодорхой заана/

15. Комиссын шийдвэр:

Комиссын дарга.

Цол, гарын үсэг, нэр /...../

Нарийн бичгийн дарга:

Цол, гарын үсэг, нэр /...../

Гишүүд

Цол, гарын үсэг, нэр

..... /...../

..... /...../

..... /...../

..... /...../

..... /...../

..... /...../



Цэргийн тэв эмнэлгийн дарга-  
ерөнхий эмчийн 2023 оны 7 дугаар  
сарын 21-ны өдрийн 7 дугаар  
тушаалын дөрөвдүгээр хавсралт

YKB0050 9095764

## ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫН ТУХАЙ ЯАРАЛТАЙ МЭДЭГДЭХ ХУУДАС

1. Аж ахуйн нэгж, байгууллагын нэр .....
  2. Цех, тасгийн нэр .....
  3. Осол, хурц хордлогын хэлбэр: хөнгөн, дунд, хүнд, хүн нас барсан, бүлэг осол /зурах/
  4. Осол, хурц хордлогод өртсөн хүний тоо .....
  5. Осол, хурц хордлого гарсан ..... он ..... сар ..... өдөр ..... цаг .... минут
  6. Мэдэгдэл өгсөн ..... он ..... сар ..... өдөр ..... цаг .... минут
  7. Осол, хурц хордлогын тухай мэдээлэл .....

.....

.....

.....

.....

.....

.....

Энэхүү мэдээллийг .....  
..... нарт өгсөн болно.

**Тайлбар:** Мэдэгдлийг бичгээр, утсаар өгч болно. Мэдэгдлийг утсаар өгсөн тохиолдолд хаана, хэнд мэдэгдсэн тухайгаа энэхүү хуудсанд бичиж, осол, хурц хордлогын материалд хавсаргана.

## Мэдэгдэл өгсөн:

Албан түшаал

## Цол гарын үсэг, нэр

Цэргийн төв эмнэлгийн дарга-  
рөнхий эмчийн 2023 оны 7 дугаар  
сарын 21 -ны өдрийн 14:00 дугаар  
тушаалын тавдугаар хавсралт

1117138660

УКБ0050 9095764

Үйлдвэрийн ослын хурлын бүртгэл

№.....

Огноо:

Байршил:

Хурал удирдах:

№	Ажилтны овог, нэр	Албан тушаал	Хуралд ирсэн цаг	Хуралд хамрагдсан гарын үсэг
1				
2				
3				
4				
5				
6				
7				

Ослын судалгааг хөтлөх:

Хэлэлцэх асуудал:

Ослын байршил:

Огноо:

Гарсан осол:

1. Судалгааны хүрээ:

2. Цугларсан мэдээлэл:

3. Ослын дэлгэрэнгүй мэдээлэл:

3.1. Ослын дэлгэрэнгүй:

3.2. Шуурхай авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

3.3. Бусад тогтоогдсон нөхцөл байдал:

4. Таамаглалт боловсруулалт, туршилт

Таамаглал:

Батлах ажиглалт

Няцаах ажиглалт

Таамаглал:

Батлах ажиглалт

Няцаах ажиглалт

5. Ослын гол хүчин зүйлс

Тоног төхөөрөмж:

Хүн:

Нөхцөл байдал:

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ